

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

МОНГОЛ УТГЫН СУРГААЛЫН ХУРЛААС НАЙРУУЛАН ХЭВЛҮҮЛСЭН
“УЛААН БАРС” СЭТГҮҮЛИЙН ОНЦЛОГ

С.Отгонбаяр*

* ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн Сонин мэдээ хэвлэлийн салбарын профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үг: Монгол утгын сургаалын хурал, “Улаан барс ” сэтгүүл, монгол утга соёл, дармалал дэвтэр, нэгдүгээр дэсийн булан, чулуун бар

Агуулгын товч

Монгол утгын сургаалын хурал 1927 онд Бээжинд байгуулагджээ. “Улаан барс” сэтгүүл бол тус хурлын байгууллагын сэтгүүл юм. Тус сэтгүүл нь 1206 оны улаан барс жилд Чингис хааны хаан сууринд суусны XII жарны улаан барс жилийг дурсахын төлөө “Улаан барс” гэж нэрлэжээ. “Улаан барс” сэтгүүл нь 1927-1944 онд нийт 10 дугаар гарч, түүний “Монгол угсааны утга соёлыг боловсруулан хөөргөх” сэтгүүл найруулах зорилгоороо монгол соёлын хөгжилд гүн нөлөөлжээ.

“Улаан барс” сэтгүүл бол Монгол утгын сургаалын хурлын байгууллагын сэтгүүл юм. Тус сэтгүүл 1927 онд хэвлэл эхлүүлж, 1944 он болтол нийт 10 дугаар хэвлэгдэн гарчээ. Үүнд Бээжинд нийт 3 дугаар хэвлэгдэж, Кайлуд 7 дугаар хэвлэгдэв. Одоохон-

доо тус сэтгүүлээс 4, 5, 6, 9, 10 дугаар нь олдож буй. Цаг төрийн ороо бусгаа, хурлын бууц суурийн тогтворгүй ба дармалласан тооны багаас болж, “Улаан барс” сэтгүүлийн нэгээс гуравдугаар хийгээд долоо, найм дахь дугаар нь нэгэнт олдохоо болив. Тухайн үед хурлын газраас данс эвхмэлийн бүтээн байгуулалтын хэрэгцээгээр “Улаан барс” сэтгүүлийн тавдугаарын зургадугаар тэмдэгт “Тус хурлын газарт урагш дармаллан гаргасан хэдэн зүйлийн хуучин бичгүүдийг шинэ бичгүүдээр сольж авахаа мэдэгдэхийн учрыг” нийтэлж “Улаан барс” хэмээх сэтгүүл 1, 2, 3 дугаарын бичгийг тус бүр “нижгээд дэвтэр илгээсэнд хөх судар нэгэн дэвтэр. Ганц нэгэн хугацааны болвоос дэвтэр бүр хөх туг, и зенг лью, ци хунг тинг алиныг дуртайг нэг иж хүргэж өгмой” гэж “Улаан барс” сэтгүүлийн алдагдсан энэ хэдэн хугацааг эрин сурч байсан боловч үр бүтээмжээр хангамжгүй байлаа.

“Улаан барс” сэтгүүлийн нэрийдлийн ирэлт монгол үндэстний түүх лугаа холбогдохын учир түүнд түүхэн агуулга

зузаан агуулагджээ. Үүний тухай “Улаан барс” сэтгүүлийн 10 дугаарын 1, 2-р нийлмэл тэмдэгт нийтлэгдсэн “Улаан барс”-ын тайлбарт уул дармалыг яахин улаан барс хэмээсэн аж, тэр нь суут богд Чингис хаан улаан барс жил (1206 он)-ийн 12 сарын нэгнээ даруй эдүгээгээс 732 оны урьд, Онон мөрний хөвөөнд 9 хөлт цагаан тугаа босгон, хаан сууринаа эрхшээсэний тул энэ орноор өнө үүрдийн дурсгал болгон түүний 12 дугаар жарны улаан барс жилд уул хурлыг үүдэн байгуулж сарын дармалын нэрийг улаан барс хэмээсэн болой гэж тус сэтгүүлийн нэрийдлийн ирэлтийг тайлбарласан байдаг. Тус сэтгүүл уул нь сар тутмын сэтгүүлээр хэвлэгдэх төлөвлөгөөтэй байжээ. Гэвч эл зүйлийн бусад нөхцөлөөс шалтгаалж, 1-4 дугаар хүртэл тогтмол бус хугацаагаар хэвлэгдэж 1939 оны 5 дугаарын нэгдүгээр тэмдэгт “Улаан барс” хэмээх сэтгүүлийг “тавдугаар хугацаанаас эхлэн сар бүрийн эцэст хэдэн хуудас дарамлаж гаргахаар тогтоосон” гэж тунхагласнаас эхлэж сая сар тутмын сэтгүүл болж хэвлэгдэв. “Улаан барс” нь байгууллагын сэтгүүл болсны хувьд эхний үедээ эрдэм шинжилгээний шинжтэй сэтгүүл, нэн бодитой яривал “хурлын нөхдийн ажил хийсэн мэдүүллийг цуглуулан нийлүүлж” нийтэлдэг байжээ.

Хожмын хурлын ажлын урагштай болохыг дагалдан тус сэтгүүлийн шинж чанарт ч хувиралт гарч, эрдэм шинжилгээний сэтгүүл байснаасаа ерөнхийлсөн шинжтэй сэтгүүл болж хөгжжээ. Үүнээс цаашилбал тус сэтгүүлийн хэлбэр нь шинэчлэгдэж агуулга нь баяжжээ. “Улаан барс”

сэтгүүл бол үндсэндээ сар тутмын сэтгүүл болох юм. Тус сэтгүүл нь 19 см*26 см зүсмээр сар бүрийн сүүлчээр хэвлэгддэг байжээ. 19 дугаар хүртэл чулуун бараар хэвлэгдэж, сэтгүүлийн монгол, хятад, япон, манж зэрэг үсгийг Ширангаа, Сайнбилигт нар сийрүүлэн бичдэг байжээ.

XX зууны 20, 30-аад оны үеэр монгол сэтгүүлүүд нь 6 см*10см (“Монголын тариалан орон”), 18 см*25 см (“Дотоод Монголын ардын сэтгүүл”), 17,5 см*27 см (“Монгол хошуунд тархаах арван өдрийн дармал”), 18,5 см*25 см (“Монгол түвдийн долоон өдрийн сэтгүүл”), 18 см*25 см (“Монголын долоон өдрийн дармал”), 15 см*21 см (“Шинэ Монгол”) зэрэг зүсмээр хэвлэгдэж байсан болохоор “Улаан барс” сэтгүүлийн иймэрхүү зүсэм нь тухайн үедээ баримжаа зүсэмдээ тооцогдоно.

Тус сэтгүүл нь 10 дахь дугаараас эхэлж хорголжингоор хэвлэгдэх болсон юм. Тав дахь дугаараас эхлэн хугацаа бүр 12 тэмдэгтэй, тэмдэг бүр 30-40 хэдэн нүүртэй хэвлэгдэв. Тэмдэг бүрийг сарын сүүлчээр дармалддаг бөгөөд 12 тэмдэг бүрдвэл жилийн эцэст нэг хугацаа болгож дэвтэрлэдэг. “Улаан барс” сэтгүүл нь хавтасны урлал чимэглэлийг маш хүндэтгэж байв. Чулуун бараар хэвлэгдсэн эхний дугааруудын сэтгүүлийн хавтасны урлалыг Хөлөнбуйр аймгийн Ботха хошуунд нутагтай Эрхээ гүйцэтгэв. Тэр монгол гор үсгийн дүрс бүтээх урлалын мэргэжлийг үндэслэж, “Монгол утгын сургаалын хурал” гэх үсгийг ашиглаж сэтгүүлийн нүүр хавтас ба ар хавтсыг тус тус урлан чимсэн байдаг. Өмнө

хавтасны урлалд “Монгол утгын сургаалын хурал” гэх гор үсгээр эгц хаданд оцойн суугаа барс ба туг өргөн хошуурч яваа эгнээ анги хоёр хувь зургийг бүтээжээ. Хад хийгээд барсыг “монгол”, “утга”, “-ын” гэх 3 үсгээр урлаж онцгойлон оцойн архираа барсыг “монгол” гэх үсгээр сүрлэг бүтээсэн нь эчнээ далд утга санааг бэлгэдэн үзүүлжээ. Туг өргөн хошуураа эгнээ анги нь “сургаал”, “-ын”, “хурал” гэх гурван үсгээр бүрэлдэв. Хадан түшилгэд түрэн урагшлах эгнээ анги нь монголчуудын өнгө гэрэлт түүхэн жавхааг дуурайлган харуулав. Тус урлал нь “Улаан барс” сэтгүүлийн хавтасны урлалд илрэхээр барахгүй, бас зарим номын хавтасны урлалд ч илэрдэг. Сэтгүүлийн ар хавтас “Монгол утгын сургаалын хурал”

гэх үсгээр урлагдсан том хонхоор чимэглэгдэв. Хонх нь илт мансууран нойрсоо монгол угсаатныг дугжирсан нойрноос нь дуудан сэрээх гэсэн санаатай. Иймэрхүү чимэглэл урлал нь Монгол утгын сургаалын хурлын “Монгол угсааны утга соёлыг бадраан хөгжөөх” гол зорилтыг урлагийн хэлбэрээр дүрслэг илтгэн чаджээ. Тус урлалд маш гүнзгий санаа агуулагдсанаас “Улаан барс” сэтгүүлийн нүүрний чимэглэлд ч олон илэрнэ.

“Улаан барс” сэтгүүл нь 10 дахь дугаараас эхлэн хорголжингоор

хэвлэгдэх болов. Чухал зохиолын гол агуулгыг хавтасны нүүрт илрүүлэх бол энэ үеийн “Улаан барс” сэтгүүлийн хавтасны урлалын гол онцлог болж байв. Жишээлбэл: “Улаан барс” сэтгүүлийн 10 дахь дугаарын долдугаар тэмдгийн өмнө хавтасанд “Чингис богдын хатан авах хуримд архийг цээрлэсэн” гэх зохиолын гол агуулгыг хорголжингоор дарамлаж “Улаан барс” гэх гор үсгийн томоохон

сийлмэлийг агуулгын дээд хэсэгт илхэн үзүүлсэн байдаг. Хавтасны урлалыг сэтгүүлийн агуулгатай нэгдэлтэй болгох, цаг үеийн онцлог хийгээд үндэстний хэв намбыг харуулах, тогтворт шинж хийгээд хувьсангуй шинжийн уялдлыг биелүүлэх бол “Улаан барс” сэтгүүлийн хавтасны урлалын баримтлал

байв. Энэ нь мөн ч тухайн үеийн хавтасны урлалын нийдмийн хөөцөлдөл байв. “Дундад улсын эрт үеийн сэтгүүлийн хавтасны төсөвлөлд гоо таашаалын чадавх байсангүй юм. “5 дугаар сарын 4”-ний хөдөлгөөний сүүлээр Лү Шюйний дурдалгаар сэтгүүлийн хавтас нь цулгуй хэлбэрээсээ урлал чимэглэлийн хэлбэр зүг хөгжиж эхэлсэн юм”¹.

“Улаан барс” сэтгүүлийн хэвийн нүүрийн төсөвлөл нь хэрчимгүй шууд барлах номын хэлбэр ба олон хэрчмээр урлан барлах сонины

«

Сэтгүүлийн ар хавтас “Монгол утгын сургаалын хурал” гэх үсгээр урлагдсан том хонхоор чимэглэгдэв. Хонх нь илт мансууран нойрсоо монгол угсаатныг дугжирсан нойрноос нь дуудан сэрээх гэсэн санаатай. Иймэрхүү чимэглэл урлал нь Монгол утгын сургаалын хурлын “Монгол угсааны утга соёлыг бадраан хөгжөөх” гол зорилтыг урлагийн хэлбэрээр дүрслэг илтгэн чаджээ

»

хэлбэрээр хяналт болгожээ. Сонины хэлбэрээр хяналт болгосон нүүрийн төсөвлөл нь 2- 4 хэрчимтэй байж, хааяа бас нүүрийн төвд дүгрэг, дөрвөлжин, эсвэл зүсгэлжин хэрчимд зохиолын агуулгыг барлах ч буй. Тэмдэг эхлүүлсэн нүүрийн эхэнд хурлын тэмдэг, сэтгүүлийн нэр, сэтгүүлийн хугацаа хийгээд тэмдэг, дармал явуулах газар, дармал явуулах хүн, дармал гаргасан өдөр зэрэг агуулгыг тэмдэглэж, дараагаар гарчиггүйгээр эл зохиолыг шууд барладаг. Сэтгүүлд зургийн урлал цөөн харагдана. Энэ нь тус сэтгүүлийн олонх дугаар нь чулуун дармалаар дарамлагдаж, дармалын мэргэжлээс шалтгаалсан байж мэднэ. Хэдийгээр ийм боловч хааяа илрэх зурагнууд нь нэлээд уран нарийлаг харагдана. Жишээлбэл, тав дахь дугаарын дөрөвдүгээр тэмдгийн есдүгээр нүүрт илэрсэн эл үндэстний зураг нь дүр төрх амьдлаг тодорхой байж, илтгэх агуулгаа төгөлдөр дурайлгаж чаджээ. Хэвийн нүүрт хааяа буруу сийлбэрлэж дарамласан үг үсгийг улаан өнгөөр хажууд нь залруулсан харагдана.

Булан бол “Улаан барс” сэтгүүлийн эх бичгээ ангилан эмхэлж, сэтгүүлийн агуулгаа дэлгэн үзүүлэх арга хэрэглүүр болж байсан юм. Тус сэтгүүлийн булангийн тохируулгад Монгол утгын сургаалын хурлын гол зорилт тууштай найдваржуулагдав. “Улаан барс” сэтгүүлийн булан нь үндсэндээ тогтвортой зарчим баримталж найруулагдав. Үүнд “Уул хуралд тусалсан халуун сэтгэлт хүмүүсийн нэрийн илтгэл”, “Хурлын хүрээ”, “Хурлын гишүүн” гэх гурван булан нь тогтмол болж, тус сэтгүүлийн

1-10 дугаар хүртэл харагдана. Эдгээр буланд монгол утгын сургаалын хуралд хөрөнгө мөнгөөр туслагсдын нэр, хурлын газрын орлого, зарлага хийгээд хурлын гишүүдийн ажил хийсэн мэдүүлэлтийг нийтэлдгээс сэтгүүлийн чухал булан болсон нь тодорхой. Эдгээр булангийн хүндэтгэсэн нь тус сэт-гүүлийн хэвлэл эхлүүлэх үеийн “Тус хурлын хэрэг мэдэгчийн товчооноос хурлын нөхдийн ажил хийсэн мэдүүлийг цуглуулан нийлүүлсээр дарамлал гаргаж болмоор үед даруй нэгэн зүйлийн тогтоосон хугацаагүй дарамлал дэвтрийг дарамлан гаргамай” гэсэн сэтгүүл эрхлэх сэдэл ба “Уул хурал эдүгээ хурлын дүрмээ мөрдөж энх эрдэмтийн зургадугаар оны нэгэн сараас хойшх “Улаан барс” хэмээх сэтгүүлийн тавдугаар хугацаанаас эхлэн сар бүрийн эцэст хэдэн хуудас дарамлаж гаргахаар тогтсоны тул мөн нэгэн сарын доторх аливаа уул хуралд ашгаар тусалсан халуун сэтгэлт хүмүүсийн нэр алдраас тэргүүлэн хурлын гишүүн хийгээд тушаалтан ба зоос мөнгөний орлого, зарлага, хурлын гишүүний ажил хийсэн мэдүүлэлт жишээ нь, бас хурлын хамаатай аливаа явдлыг тодорхой тэмдэглэж гаргаад, одоох хурлын үнэн явдлаа олон түмэнд цаг тухайд нь мэдэгдэхээр гол зорилт болговай”² гэсэн илтгэл нийтлэлтэйгээ нийцнэ.

“Улаан барс” сэтгүүлийн булан нь дэгтэрлиг шинжтэй. Жишээлбэл, 4-6 дахь дугаар хүртэлх сэтгүүлийн “Хурлын гишүүн” гэх нэгдүгээр дэс буланд үндсэндээ “Шинэ орсон хурлын гишүүн”, “Нас нөгчсөн хурлын гишүүн”, “Хурлын гишүүний ажил хийсэн

мэдүүлэлт” зэрэг хоёрдугаар дэсийн буланг харьяалуулсан байдаг. Үүний дагууд бас сэтгүүлийн буланд булан солигдох буюу булан дэс дээшлэх үзэгдэл харагдана. Жишээлбэл, “Шинэ орсон хурлын гишүүн”. Хоёрдугаар дэсийн булан нь заримдаа “Хурлын хүрээ” нэгдүгээр дэсийн буланд харьяалагдаж, заримдаа “Хурлын гишүүн” нэгдүгээр дэсийн буланд харьяалагддаг. “Ерийн мэдэл” булан нь 9 дэх дугаарт хоёрдугаар дэсийн буланд байснаа 10 дахь дугаарт харин нэгдүгээр дэсийн буланд дээшилсэн байдаг. Энэ нь тус булангийн чухал чанарыг харуулснаар барахгүй, бас сэтгүүлчдийн сэтгүүл эрхлэх явцдаа сэтгүүлийн агуулга хийгээд хэлбэрт тасралтгүй шинэчлэлт хийж байсан үзэгдлийг харуулна.

“Улаан барс” сэтгүүлийн буланд тасралтгүй шинэ элемент нэмэгдэж сэтгүүлийн агуулгыг баялагжуулдаг. Арав дахь дугаарт сэтгүүлийн хуудсанд “Уул хуралд тусалсан халуун сэтгэлт хүмүүсийн нэрийн илтгэл”, “Ажил хийсэн нь”, “Ерийн мэдэл”, “Түүх судар”, “Эрүүл хамгаалах”, “Газрын зүй”, “Утга уянга”, “Эрдэмтний шашдир”, “Инээдэм үг”, “Шинжил ухаан”, “Байлдааны ухаан мэдэл”, “Үлгэр” зэрэг олон булан гарч “Улаан барс” сэтгүүлийг нэгэн жинхэнэ утган дахь ерөнхийлсөн чанартай сэтгүүл болгон хувьсгажээ. Эдгээр нийтлэлд “Улаан барс” сэтгүүл нь Монгол утгын сургаалын хурлын байгууллагын сэтгүүл болохоор сэтгүүлийн агуулга нь тус хурлын гол зорилтыг ухуулах ба найдваржуулахад үйлчилж хурлын газраас өрнүүлж байгаа бүхий л

соёлын ажиллагааг нийтлэн мэдүүлэхээр голлосон байдаг. Хуралд туслагсдын нэрийн илтгэл, хурлын газрын ажлын мэдүүлэл ба хурлын гишүүн ба бусад хүмүүсийн зохиол бүтээлийн нийтлэл зэрэг нь сэтгүүлийн хуудсын ихэнх хэсгийг эзэлж байсан юм.

Ишлэл

¹ *Цээн Рень Фен.* 1995.Одоо үеийн сэтгүүл найруулах зүй. Дундад Улсын Ардын хэвлэлийн хороо, х. 223.

² “Дагалдуулан мэдэгдэх зүйл” // “Улаан барс” сэтгүүл, №5, Нэгдүгээр тэмдэг.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Түймэр.* 1987. Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын газар орны сонин сэтгүүлийг магадалсан гарчиг. Хятад хэвлэл. Хөх хот.

2. 1979. Найман муж орны монгол хэлбичгийн ажлын хамжилцах дугуйлангийн албан гэр найруулав. “Бүх улсын монгол хуучин ном бичгийн нэгтгэсэн гарчиг”. Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэл-ийн хороо.

3. 1999. Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг. Монгол хэвлэл. Бээжин номын сангийн хэвлэлийн хороо.

4. *Лигдэн.* 1999. Хорьдугаар зууны Дундад улсын монгол уран зохиолын сэтгүүлийн дээж бичиг. Нэгдүгээр дэвтэр. Үндэстний хэвлэлийн хороо.

5. 1989. Боржигон Мөнхдалай найруулав. “Бээжингийн номын сангийн монгол хуучин бичгийн товч”. Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

6. *Төгсцогт* нар. 1999. Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм. Монгол хэвлэл. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

7. *Сүхээ Б.* 2003. Бөххишиг хийгээд “Улаан барс” сэтгүүлийн судлал. Монгол хэвлэл. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

8. *Түймэр*. Иргэн улсын үеийн хятад, монгол хуучин сонин сэтгүүл. (Монгол судлалын мэдээ занги). 2002 оны 3 дугаар хугацаа.

9. *Чойролжав*. Монгол утгын сэтгүүлийн нөхвөр магадлал. (Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл). 2006 оны 2 дугаар хугацаа.

10. *Хөхбаатар*. 1997. Дундад улсад хэвлэгдсэн монгол тогтмол хэвлэлийн хөгжилтийн түүхээс хятад хэлний нөлөөн дэх монгол хэлний орчин үеийн үгсийн бүрэлдлийг ажиглах нь. Доктор цол хамгаалах өгүүлэл.